Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Түншлэлийн төслийн хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Батмөнх Бадамханд

## 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Зорилт 5.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулна. | | | | | | | |
| 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагалдан гарах журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хэрэгжилтийн явц, хувиар | - | Холбогдох журам, аргачлалд заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна. /100 хувь/ | ТХХТ-ийн тухай хуулийг дагалдан нийт 9 журам, аргачлал 2023 онд батлагдсан. Тус хуулийн хүрээнд түншлэлээр төсөл хэрэгжүүлэхэд салбар яамнаас түншлэлийн төслийн саналыг ирүүлэх бөгөөд ийнхүү төслийн саналаа ирүүлэхдээ ЗГ-ын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу төслийн саналаа боловсруулан ирүүлэх ёстой. Үүний хүрээнд түншлэлээр хэрэгжүүлэх | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төсөл хөтөлбөрийн саналыг холбогдох журамд заасан маягт , мэдээллийн дагуу авах, мөн холбогдох байгууллагад заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна. ЗТЯ-аас "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл", "Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл" нийт 2 төсөл, ЭХЯ-аас "Майхан 18МВт усан цахилгаан станц төсөл"-үүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх санал ирүүлсэн бөгөөд төслүүдийг судлан урьдчилсан үнэлгээг салбар яамтай хамтран дүгнэлтийг гаргасан. Одоогийн байдлаар "Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл", "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл"-ийн урьдчидсан үнэлгээг хийж дүгнэлтийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу СЯ-аас уг төслийн урьдчилсан үнэлгээний дүгнэлтийг хянаж саналаа ирүүлэх тухай 2024.05.06-ны өдрийн 03/935 дугаар албан бичгийг хүргүүлж, уг 2 төсөлд бүрэн шинжилгээ хийх төслийн багыг байгуулсан. ЗТХЯ, БОАЖЯ-нд 2024.05.20-ны өдрийн 03/1036 тоот албан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгээр МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд ТХХТ-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан төслүүдэд урьдчилсан үнэлгээ хийх шаардлагатай тул ТХХТтухай хууль болон ЗГ-ын 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-д заасны дагуу холбогдох төслийн саналаа ирүүлэхийг мэдэгдсэн болно. Мөн ЗГҮАХ 2024-2028-д ТХХТ-ээр хэрэгжүүлэхээр тусгагдсан төслүүдийн саналыг холбогдох журамд заасны дагуу ирүүлэх тухай 2024.09.24-ний өдрийн 01/1891 дугаар албан бичгийг холбогдох сайд нарт хүргүүлсэн болно. | | |
| 2 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон тус хуулийг дагалдан гарсан журам, аргачлалын хүрээнд сургалтыг зохион байгуулна. | Сургалт зохион байгуулсан тоо | - | Холбогдох байгууллагуудад жилийн эцэст нийт 3-аас доошгүй удаа сургалт орсон байна. | 2024 онд 3-аас доошгүй удаа сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдсан "Ашигт малтмал-Төмөр замыг холбосон Төр, хувийн хэвшлийн түншлэл олон улсын семинар"-т Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон дагалдах журмуудын талаар танилцуулж, сургалт | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орсон. 2024 оны 04 дүгээр сард Монгол Улс дахь Азийн хөгжлийн банкны оффис дээр тус байгууллагын албан хаагчдад "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль" эрх зүйн орчин болон журмуудын талаар танилцуулж, сургалт орсон болно. Мөн 2024 оны 6 дугаар сарын 13-ны өдөр холбогдох салбар яамдуудад "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль" эрх зүйн орчин, журам болон түншлэлээр хэрэгжүүлэх төслийг тодорхойлох, төслийн санал гаргах, урьдчилсан үнэлгээ хийхтэй холбоотой сургалт зохион байгуулахаар 2024.06.10-ны өдрийн 11/1192 тоот албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, сургалтыг амжилттай зохион байгуулсан. Мөн 2024.11.28-ны өдөр Боомтын сэргэлтийн үндэсний хороонд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох журмуудын талаар" сургалтыг орсон. | | |
| 3 | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг | Хэрэгжилтийн явц хувиар | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлж, Төр, | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг ЭЗХЯ тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллана. | | | хувийн хэвшлийн түншлэлийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллана. /100 хувь/ | болсоны дагуу яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй компьютер, тоног төхөөрөмж худалдан авах", "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэх албан өрөөний тохижилт" , "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ/6 зөвлөх/" зэрэг худалдаг авах арга хэмжээ тусгагдсан. ТНБД-ын 2024.03.15-ны өдрийн А/47, А/50 дугаар тушаалаар дээрх худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ/6 зөвлөх/"-ийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын зарлалыг 2024.04.01-ний өдөр нийтэлсэн бөгөөд 2024.04.24-ний өдөр тендерийг нээсэн, үнэлгээний хорооны хурлыг зохион байгуулсан. Тендер | сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгаруулалт нийт 6 багцтай зарлагдсан бөгөөд 1 багцад оролцогч шалгарсан бөгөөд амжилтгүй болсон бусад багцыг дахин 2024.05.6-нд зарлаж, 2024.05.27-ны өдөр нээсэн. Нийт 5 багцтай зарласан бөгөөд "Санхүүгийн зөвлөх", "Хуулийн зөвлөх" -д тус тус нэг, нэг зөвлөх буюу нийт 2 зөвлөх шалгарч гэрээ байгуулагдаж байна. Мөн "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэрэгцээтэй компьютер, тоног төхөөрөмж"-ийг ТБОНХБАҮХАТХуульд заасны дагуу цахим дэлгүүрээс үнийн санал дуудаж, хамгийн бага үнийн саналаар нэг оролцогч шалгаран гэрээ байгуулагдсан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн чиг үүргийг хэрэгжүүлэх албан өрөөний тохижилт"-д шаардлагатай тавилгыг харьцуулалтын аргаар зарлан 2024.05.24-ний өдөр тендер нээж, хамгийн сайн тендер ирүүлсэн нэг оролцогч шалгаран, гэрээ байгуулсан. Улмаар Засгийн газрын 2024.08.07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор "Төр, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ыг байгуулж, бүтэц, дүрмийг батлуулаад байна. | | |
| 4 | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжилтийн явц хувиар | - | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр салбар яамдаас ирүүлсэн саналыг ТХХТ-ийн хуульд заасны дагуу судлан, холбогдох арга хэмжээг авч ажиллана. /100 хувь/ | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх салбар яамдаас ирүүлсэн төслийн саналыг судлан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон журам, аргачлалын дагуу төслийн саналыг бэлтгэн ирүүлэх тухай холбогдох байгууллагуудад албан бичгээр заавар, хариуг хүргүүлэн ажилласан. Тухайлбал БОАЖЯ-нд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу түншлэлээр төсөл хэрэгжүүлэхэд төслийн саналаа Засгийн газрын 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-д заасны дагуу төслийн мэдээллээ ирүүлэх тухай 2024 оны 02/500 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл”, "Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл" нийт 2 төсөл, Эрчим хүчний яамнаас | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Майхан 18МВт усан цахилгаан станц төсөл"-үүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх санал ирүүлсэн бөгөөд төслүүдийг судлан урьдчилсан үнэлгээг салбар яамтай хамтран дүгнэлтийг гаргасан. Одоогийн байдлаар ЗТЯ-аас ирүүлсэн 2 төслийн урьдчидсан үнэлгээг хийж дүгнэлтийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу Сангийн яамнаас уг төслийн урьдчилсан үнэлгээний дүгнэлтийг хянаж саналаа ирүүлэх тухай 2024.05.06-ны өдрийн 03/935 дугаар албан бичгийг хүргүүлж, бүрэн шинжилгээ хийх төслийн багыг байгуулсан. ТХХТтухай хууль болон Бүрэн шинжилгээ хийх журамд заасны дагуу төслийн санал хүлээн авснаас хойш 30 хоногын дотор урьдчилсан үнэлгээг хийнэ гэж заасны дагуу тус хугацаанд судлан ажиллаж байна. ЗТХЯ, БОАЖЯ-нд 2024.05.20-ны өдрийн 03/1036 тоот албан бичиг, холбогдох сайд нарт 2024.09.24-ний өдрийн 01/1891 дугаар албан бичгээр тус тус Монгол Улсын хөгжлийн 2024 оны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөө, ЗГҮАХ2024-2028-д ТХХТ-ийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан төслүүдэд урьдчилсан үнэлгээ хийх шаардлагатай тул ТХХТтухай хууль болон ЗГ-ын 404 дүгээр тогтоолоор батлагдсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-д заасны дагуу холбогдох төслийн саналаа ирүүлэхийг мэдэгдсэн болно. | | |
| 5 | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч ажиллана. | Хэрэгжилтийн явц хувиар | - | Концессын гэрээний хэрэгжилт, явц, үр дүнд, хяналт тавин ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. /100 хувь/ | Концессын тухай хуулийн хүрээнд гэрээ байгуулагдан хэрэгжиж байгаа "Багануурын цахилгаан станц төсөл", "Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл", "Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл", "Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл", "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл", "Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хатуу хучилттай авто зам төсөл" төслүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн концессын гэрээний дагуу хэрэгжиж байгаа төслүүдийг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар бэлтгэл ажлыг ханган төслүүдийн хэрэгжилттэй цаашид авах арга хэмжээний талаар тухайн салбар яамнаас холбогдох саналыг авахаар ЗТХЯ-нд 2024.03.15-ны өдрийн 03/522 дугаар албан бичгийг хүргүүлсэн. "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын гэрээнд заасны дагуу Нисэх буудлын зохицуулах хорооны 2024 онд 2 удаагийн хурлыг зохион байгуулсан. Мөн тус төслийн концессын гэрээний дагуу концессын төлбөрийг тооцон, санхүүгийн хэлтэст холбогдох баримт, тооцооллыг гарган хүргүүлж, 2024 оны төлөгдөх 2023 оны сүүлийн хагасын концессын төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Хариуцсан төсөл хөтөлбөртэй холбоотой албан бичигт тухай бүр хариуг хүргүүлэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | | |
| 6 | Барих-шилжүүлэх төрлийн концессын гэрээгээр хэрэгжиж дуусах төслийн Монгол Улсын 2024 оны төсөвт батлагдсан хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг холбогдох хууль, концессын гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэнэ. | Хэрэгжилтийн явц хувиар | - | Улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг холбогдох хууль, концессын гэрээ, аудитын дүгнэлтэд нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 2024 оны Улсын төсөвт санхүүжилт нь тусгагдсан концессын барих-шилжүүлэх төрлийн гэрээгээр хэрэгжиж байгаа 1 төсөл байгаа бөгөөд тус төслийн хүрээнд бий болсон ажлыг Улсын комисс хүлээн авсны дараа төслийн гүйцэтгэлд аудит хийлгэж, тус оны санхүүжилтийг олгох арга хэмжээ авч ажиллах тул хугацаа болоогүй. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 7 | Монгол Улсын 2025 оны төсөвт тусгах концессын төслийн концессын гэрээний дагуу төлөгдөх хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн санал болон концессын гэрээний дагуу улсын төсөвт төвлөрөх концессын төлбөрийн гэрээнд заасны дагуу тооцооллыг хийж, саналуудыг Сангийн яаманд хүргүүлнэ. /Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт болон концессын төлбөрийн орлого/ | Хэрэгжилтийн явц хувиар | - | Хэрэгжилт нь дууссан төслийн Концессын гэрээнд заасны дагуу 2025 онд төлөх хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 2025 оны Улсын төсөвт тусгах саналыг хүргүүлж, мөн Улсын төсөвт төлбөр төвлөрүүлэх концессын гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу тооцоолон саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна. /100 хувь/ | 2024 онд хэрэгжилт нь дууссан "Барих-шилжүүлэх" төрлийн "Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Түшиг Зэлтэрийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам төсөл"-ийн концессын гэрээнд заасны дагуу 2025 онд төлөх хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг 2025 оны Улсын төсөвт тусгах саналыг 2024 оны 8 дугаар сард хүргүүлж, мөн Улсын төсөвт төлбөр төвлөрүүлэх "Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийн концессын гэрээний төлбөрийг гэрээнд заасны дагуу тооцоолон саналыг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сангийн яаманд хүргүүлж, 2025 оны Улсын төсвийн төсөлд тусгуулаад байна. | | |
| 8 | Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавина. | Хэрэгжилтийн явц хувиар | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ Засгийн газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан. | Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт хангагдсан байна./100 хувь/ | "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ байгуулагдсантай холбогдуулан тус төвтэй хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүлээн авч, урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээг хийж, хамтран ажиллаж байгаа бөгөөд тус төсвийн албан хаагчдад төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох журмуудын талаар сургалтыг орсон болно. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 9 | Шүүхийн маргаантай төслүүдийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох баримт, материалыг хуулийн хэлтэст гарган өгч, дэмжлэг үзүүлэх. | Хэрэгжилтийн явц хувиар | - | Шүүхийн маргаантай төслүүдийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох баримт, материалыг хуулийн хэлтэст гарган өгч, дэмжлэг үзүүлж ажилласан байна. /100 хувь/ | Шүүхийн маргаантай төслүүдийн тухайлбал "Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл", "Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл", ""Дулааны V -р цахилгаан станц төсөл", "Чойр дэд станцын өргөтгөл шинэчлэлт төсөл", "Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хурдны авто зам төсөл", "Хан-уул дүүрэгт баригдсан 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих төсөл" зэрэг төслүүдтэй холбоотой шүүхийн маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд шаардлагатай холбогдох баримт, материалыг тухай бүр хуулийн хэлтэст гарган өгч дэмжлэг үзүүлж ажилласан. | | |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 10 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилтийн явц хувиар | - | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллах /100 хувь/ | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Мөн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан болно. Тайлан гаргадаг цахим системээр Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, сар бүрийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн тайлагнаж ажилласан болно. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 11 | Архив, албан хэрэг | Хэрэгжилтийн | - | Архив, албан хэрэг | Архив, албан хэрэг | 1-р сар, 2- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | явц хувиар | | хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах /100 хувь/ | хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 140 албан бичиг /ДАБ ороогүй болно./ирж, тухай бүр холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэсэн болно. | р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тамралтгүй хөгжүүлэх. | Ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдах. | - | Ажлын чиг үүрэгтэй холбоотой сургалт, хөтөлбөрт тухай бүр хамрагдсан байна. /Хувь/ | Японы Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр ОУВС-гийн Төсвийн асуудал эрхэлсэн газраас хэрэгжүүлж буй дэд бүтцийн засаглалыг бэхжүүлэх, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Дэд бүтцийн засаглал” бүсийн семинарт оролцож, олон улсын туршлага судлах сургалтад 2024 оны 4 дүгээр сард хамрагдаж, сертификат авсан. Мөн АНУ-ын Худалдааны яамнаас хэрэгжүүлж буй Commercial Law Development Program-ын хүрээнд 2024.02.01-02 ны өдрүүд болон 2024.09.17-20 ны өдрүүдэд "Дэд бүтцийн салбарын төр, хувийн хэвшлийн түншлэлийн стратеги төлөвлөгөө", "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйлчилгээ" гэсэн сэдвүүдийн хүрээнд богино хугааны сургалтад хамрагдаж, сертификат авсан болно. Мөн долоо хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулагддаг мэдээллийн цагт оролцож, шинэлэг мэдээ мэдээлэлтэй танилцаж өөрийгөө хөгжүүлж байна. Мөн 2024 оны 2 дугаар сард АЗ-ийн сургалтад сууж, сертификат авсан болно. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Хувь хүний хөгжил | Хувь хүний хөгжил | - | Хувь хүний хөгжил | Сантис сургалтын төвд 2024.01- | 1-р сар, 2-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлсэн байх. | болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдсан байна. | | болон өөрийн сонирхсон чиглэлээр мэдлэг чадвараа дээшлүүлэх сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдсан байна. /100 Хувь/ | 02 дугаар сарын хооронд Англи хэлний сургалтад хамрагдаж Certificate авсан болно. | сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Түншлэлийн төслийн хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Батмөнх Бадамханд /Б. Бадамханд/
Огноо: 2024.12.18